

72

72
A-48



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
Н УЛСЫН ХАРИЛЦААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
Н УЛСЫН ХАРИЛЦААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
Н УЛСЫН ХАРИЛЦААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

АЛТАН АРГАМЖ

Altan Argamj

Journal of foreign affairs & studies

VOL.3 (166)

3/2000



Улаанбаатар хот.

Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРГАМЖ

АЛТАН АРГАМЖ

VOL.3

1/2000

ОЛОН УЛСЫН БОДЛОГОЗҮЙН ОНОЛЫН АСУУДАЛД

МУИС, ОУХС-ийн
захирал Ж.Бор

I. Олон улсын бодлогозүй гэж юу вэ.

Олон улсын харилцаа буюу дэлхийн тавцан дээр улс орнууд өөр өөрийн гэсэн онцлогтой гадаад бодлогыг журамлан явуулж байдаг бөгөөд тэдгээр нь хоорондоо зөрчилдөх ба зохицон найраж байдаг. Энэхүү зөрчил ба зохицон найрлын диалектик холбоонд дэлхийн их бодлогын мөн чанар оршин байдаг билээ. Тиймээс олон улсын харилцаанд байр сууриа эзлэхийг эрмэлзсэн улс орон бүр дэлхийн болоод бүс нутгийн их гүрнүүд ба бусад орнуудын гадаад бодлогын сүлжилдээнээс бүрдсэн дэлхийн их бодлого, түүний хандлага, цар хүрээ, хэтийн төлөвд үнэлэлт дүгнэлт өгч өөрийнхөө бодлогыг уян хатнаар зохицуулж байх оролдлого байнга хийдэг.

Дэлхийн их бодлогод оролцож буй улс орнууд өөрсдийнхөө хүчин чадавх, байр сууринаас хамааран гадаад (бодлогоо) бодлогынхоо чиг шугамыг боловсруулан гаргаж байдаг. Тухайлбал их гүрнүүдийн гадаад бодлого universal буюу өргөн цараатай, бага орных imperialist буюу ерөнхий шинж чанартай байдаг.

Гадаад бодлогын зорилго, зорилтуудыг хангах хамгийн үр ашгитай арга барил, хэрэгслийг олж тогтоох ажлыг хийхдээ "гадаад бодлогын онолд" тулгуурлах зайлшгүй шаардлагатай. Мөн түүнчлэнгээр гадаад бодлогыг төлөвлөх, гадаад бодлогын алхамыг зохиорлоулах, гадаад бодлогын шийдвэр гаргах арга барилыг боловсронгуй болгоход ч үүнийг нарийн харгалзах



шаардлагатай байдаг.

Аливаа улс гадаад бодлогоо гаргаж ирэхдээ хоёр үндсэн чиглэлээр ул суурьтай, өргөн цар хүрээтэй ажил хийсэн байх ёстой. Үүнээс тэр улсын гадаад бодлого дэлхийн их бодлогод ямаршуу байр суурь эзлэх вэ гэдэг нь шийдэгдэж байдаг гэж хэлж болно. Тэгэхлээр дээр дурдсан хоёр чухал ажил чухам ямар ажил байх нь вэ.

Нэгдүгээрх нь "гадаад бодлогын төлөвлөлт" юм. "Гадаад бодлогын төлөвлөлт" гэдэг нь гадаад бодлогын өмнө тавьсан зорилго, зорилтуудыг ханган хэрэгжүүлэхэд чиглэсэн төр засгийн алхам, үйл ажиллагаа, арга хэмжээг алс хэтийн бодолтойгоор боловсруулан гаргаж ирэхийг хэлж байгаа билээ.

"Гадаад бодлогын төлөвлөлт" нь улс орны их багаас шалтгаалалгүйгээр хэд хэдэн үе шаттай байдаг. Тухайлбал олон улсын харилцааны системийн хөгжил хувьсалд бүхэлд нь хийгээд тухайн улс ба бусад орнуудын хоорондын харилцаанд үнэлэлт дүгнэлт өгөх, гадаад бодлогынхоо зорилгод хүрэхэд ашиглаж болох нөөц бололцоо, хэрэгслийн цар хэмжээг тогтоох, гадаад бодлогын зорилго, зорилтуудыг улс төрийн болоод эдийн засгийн ашиг сонирхолынхоо үүднээс олон чиглэлээр тодорхойлон гаргах, гадаад бодлогынхоо зорилтуудыг хэрэгжүүлэх цогц төлөвлөгөөг боловсруулан гаргах, засгийн газраас батласан гадаад бодлогын зорилтуудыг бодитойгоор хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулах гэх мэт болно.

Ингээд дээр цухас дурдаад орхисон хоёрдахь чухал ажлын тухай товчхон ярилцъя. "Олон улсын харилцааг задлан шинжих" ажил бол тэрхүү хоёрдахь нэн чухал ажил мөн. Энэ нь дэлхий дахины болоод бүс нутгуудын олон улсын харилцааны хөгжлийн болзошгүй хэтийн төлвийг тодорхойлох, олон улсын харилцааны системийн аль нэг бүрэлдүүн хэсэг, эсвэл бүрэлдүүн хэсгийн хэд хэд нь өөрчлөгдөж болох болзошгүй байдлын хандлагад задлан шинжилгээ хийх, гадаад бодлогынхоо алхамаас урсан гарч болзошгүй үр дагаврыг тооцох оролдлого хийнэ гэсэн ойлголт юм.

Үүнтэй буюу "олон улсын харилцааг задлан шинжих" асуудалтай холбоотойгоор эцэст нь хэлэхэд энэ салбарт задлан шинжилгээ хийх ажил бол нийгмийн судалгаа явуулах ажлын хэлбэрүүдээс хамгийн хэцүү нь юм.

Тэгэхлээр гадаад бодлого, гадаад бодлогын чиг шугамыг боловсруулах, тодорхойлон гаргах явдал нь дээр бичсэнээс үзэх аваас гурван үндсэн элементээс бүрддэг байхнээ. Тухайлбал улс төрийн гадаад бодлогын онол, гадаад бодлогын төлөвлөлт ба олон улсын харилцааг задлан шинжих гэх мэтэс ажээ. Өөрөөр хэлбэл аливаа үйлсийг хэрэгжүүлэхэд заавал мөрдөх үйл ажиллагааны гурвалсан бүтэц буюу "онол-загвар-хэрэгжүүлэх арга" гэсэн нэгдэлд захирагдаж байна. Тэгэхлээр "улс төрийн гадаад бодлогын онол" дээрх бүтцийн "онол" гэсэн бүрэлдүүн хэсгийг бүрдүүлж өгч байна. Харин "гадаад бодлогын төлөвлөлт" ба "олон улсын харилцааг задлан шинжлэх" нь хамтдаа "хэрэгжүүлэх арга" гэсэн бүрэлдэхүүн хэсгийг бүрдүүлж байна гэж энэ тохиолдолд хэлж болно. Улс орнууд гадаад бодлогоо хэрхэн загварчлахаа өөрсдөө үндэснийхээ онцлогт захируулан гаргаж ирдэг учраас улс бүрийнх харилцан адилгүй байдаг. Хамгийн чухал нь энэ гурвыг хооронд нь уялдуулан диалектик холбоонд оруулсан байх ёстой.

II. Олон улсын бодлогогүй улс төр судлалын тусгай хэсэг болох нь

Улс төр судлаачдын нилээд хэсэг нь эртний грекийн түүхч Фукидидийг улс төр судлалын үндсийг тавьсан гэж үздэг.¹ Түүнийг МЭӨ 431-404 онд элпадын хоёр хот улс Спарт, Афины хооронд болсон Пелопоннесийн дайны түүхийг бичиж байхдаа "улс төрийн реализмийн сургуулийн" суурийг босгосон гэдэг билээ.² Тэрбээр цэцэглэн хөгжиж байсан хоёр хот улсыг чухам ямар шалтгаан урт удаан хугацааны мөргөлдөөнд хүрэгвээ гэдэг талаар бодолхийлэн байгаад уг дайн Афин хотын хүчирхэгжилтийн хэт хуримтлалаас (илтүүдэл хүчнээс) үүдэн гарсныг олж тогтоон дүгнэлт хийжээ.³ Фукидидийн үзэж байснаар гадаад бодлогод хүч хэрэглэх явдал нь хүчирхэг этгээдийн (хүчирхэг улс гүрний) улс төрийн эрмэлзэл бөгөөд аливаа зөрчил мөргөлдөөн нь хот улсуудын хоорондын харилцааны хэвийн нөхцөл байдал буюу хүчин чадалаа нэмэгдүүлэхэд чиглэсэн "хүмүүн (төрөлхтөн)-ий дотоод ертөнцөөс"

¹ Г.Н.Новиков. Теории международных отношений. Иркутск. 1996. с.10-11

² Мөн тэнд. 11 дэх тал

³ Мөн тэнд

урсан гарч байдаг хэвийн бүс эрмэлзэл ажээ.⁴ Ийнхүү Фукидид нь эртний элладын гүн ухаантнуудын дотроос эн түрүүнд "улс төрийн реализмийг" үндэслэхдээ төр улсын гадаад бодлого буюу гадаад бодлогын шууд үргэлжлэл болсон дайны асуудлыг нягталж байгаад шинийг сэджээ. Гэтэл тэр цагийн элладын гүн ухаантанууд хот улсуудын төрийн дотоод бүтэц ба нийгмийн үнэт зүйлс гэж үзэж байсан иргэдийн эрх чөлөө, түүнийг хангах хийгээд хамгаалах асуудалд голлон анхаараад хот улсуудын хоорондын харилцааны асуудлыг маш бага анхаардаг байв.⁵

Эртний Элладад олон улсын харилцаа, гадаад бодлогын чиглэлээр хөгжиж байсан хоёрдох үзэл нь стоикуудын гүн ухааны сургууль буюу нэгэн хэсэг тэдний сартвахи гэгдэж байсан Зеноны үндэслсэн чиглэл гэж үздэг. Стоикууд нь бүрэн хэлбэржсэн улс төрийн номлол гаргаж ирээгүй боловч эллинизмын үеийн "космополизийн" үзэл санаа буюу "гур их хот улсын" тухай үзэл санааг дэвшүүлэн гаргаж ирсэн юм.⁶ Стоикууд нь Платоны үзэл бодлыг авч цааш нь хөгжүүлэхдээ эртний элладын дэлхий дахиныг төсөөлөх төсөөллийн хүрээнд нэгдмэл ертөнцийг бий болгох, гур их хот улсыг байгуулах үзлийг гаргаж гүн ухааных нь айнуудыг боловсруулсан билээ. "Космополизийн" үзэл санаа гарч ирсэн нь эртний элладын сэтгэлгээг автономит хот улсуудын хүрээнд баригдсан олзноос чөлөөлж, хүн төрөлхтөний ухамсрын нэгдлийг ухааруулах анхны дохио болж өгсөн юм.⁷ Үүнээс харахад эртний Элладад үүсэж хөгжиж байсан улс төрийн сэтгэлгээний хоёрдахь энэ чиглэл нь ч шинийг гаргаж ирэхдээ мөн л олон улсын харилцаа, гадаад бодлогын асуудлыг хөндсөн байна. Өөрөөр хэлбэл улс төр судлал үүсэн гарч ирэх анхны цаг мөч нь гадаад дотоод бодлогын диалектик холбоог олж тогтоон, олон улсын харилцааны үйл явдал, гадаад бодлогын асуудалд судалгаа хийж эхэлсэнтэй холбоотой ажээ. Ийнхүү өрнө дахины улс төр судлал суурь үндсээ тавихдаа улс төрийн бодлогыг судлах салбарынхаа хүрээг асар өргөн хүрээтэй буюу гадаад, дотоод бодлогыг нэгдмэл нэгэн цүл ойлголтонд оруулж олон улсын харилцааны бүх салбар дахь үйл

явцын өргөн дэвсгэр дээр судалж байхаар зохион байгуулагдсан юм. Тодруулах аваас эртний элладын улс төрийн сэтгэлгээнээс эх үүсвэртэй өрнө дахины улс төрийн шинжлэх ухаан нь өдгөө олон улсын харилцааг албан ёсны гурван судлалаар судалдаг боллогоо хөгжиж дэвжсээр ирсэн байна.

Гэтэл социалист системд хамрагдан орсон дорнод Европ, азийн орнуудад улс төрийн шинжлэх ухаан Өрнө дахинтай харьцуулбал харьцангуй хойно хөгжиж эхэлсэн төдийгүй ихээхэн явцуурч, Фукидидийн үеэс өмнөх үеийн элладын үе шиг зөвхөн дотоодын улс төрийн асуудлын хүрээнд цовчиж байлаа. Түүгээр ч зогсохгүй 1989 он хүртэл социалист орнуудад улс төрийн шинжлэх ухаан гэж нэрлэгдсэн шинжлэх ухааны салбар байхгүй байв. Энэ нь улс төрийн шинжлэх ухааныг бүрдүүлдэг зарим салбарын судлалуудыг шинжлэх ухааны өөр салбаруудад тараан өгч хэт явцуурсантай шууд холбоотой байсан бөгөөд үүний улмаас улс төрийн шинжлэх ухаан гэдэг шинжлэх ухааны бие даасан салбар гарч ирж чадахгүй улс төр судлал төдий хэмжээнд явсаар ирсэн билээ.

Харин ЗСБНХУ-д 1986 онд Горбачёвын улс төрийн шинэ сэтгэлгээ гарч ирснээр социализмын улс төрийн сэтгэлгээний явцуу хөгжлийн үе эцэслэх хандлагатай болсон юм. Тухайлбал улс төрийн явцуу сэтгэлгээг эвдэх, улс төрийг өргөн харж, өргөн сэтгэх шинжлэх ухааны салбарын хөдөлгөөн хүчтэй өрнөж эхэлсэн билээ. Тэдгээрийн нэг нь 1989 оны 9 дүгээр сарын 13-14-ний хооронд Москва хотноо ЗХУ-ын ГЯД-ны Дипломат Академийн Олон улс судлалын методологийн төв, Эрхүүгийн Улсын Их Сургуулийн Шинэ, нэн шинэхэн үеийн түүх ба олон улсын харилцааны тэнхим хамтарч зохион байгуулсан "Улс төрийн шинэ сэтгэлгээ (олон улсын харилцааны онол, аргачлал ба загварчлалын асуудлууд)" сэдэвт шинжлэх ухааны чуулга уулзалт байлаа. Энэхүү чуулга уулзалтын явцад "өдгөө олон улсын харилцааг албан ёсны гурван судлалаар дамжуулан судалж байна" гэж томъёолсон өрнөдийн томъёоллыг хүлээн зөвшөөрч "Тэдгээр нь олон улсын эрхзүй буюу хуулийн шинжлэх ухааны

⁴ Дээр дурдсан зохиол, 11 дэх тал

⁵ Мөн тэнд

⁶ Мөн тэнд

⁷ Мөн тэнд

* Новое политическое мышление: проблемы теории, методологии и исследования международных отношений. Материалы научного симпозиума (Москва, 13-14 сентября 1989г.). Иркутск, 1991, с.26

гадаад салбар, гадаад бодлогын түүх ба олон улсын харилцаа буюу түүхийн шинжлэх ухааны гадаад үргэлжлэл, олон улсын эдийн засгийн харилцаа буюу эдийн засгийн шинжлэх ухааны гадаад үргэлжлэл мөн. Эдгээр тусгай судлалууд дээр Өрнө дахинд улс төрийн шинжлэх ухаан ба улс төр судлалын гадаад хэсэг буюу олон улсын бодлогогүйг хөгжүүлж байна” хэмээн албан ёсоор чиглэлээ товлож, улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэхийн чухлыг тодорхойлсон. Ингэж онолын сэтгэлгээгээ цэгцэлж авсан нь ЗХУ ба өдгөө ОХУ-д улс төрийн шинжлэх ухаан өрнөдийн жишгээр хөгжиж эхлэх боломжийг нээж өгсөн гэж хэлж болно.

Гэтэл монголын судлаачид эрин үеийн шаардлагыг эс анхааран хөгжил дэвшлийн үйл явцаас хөндий сүүл барьсаар баях байдгаараа байсаар байгаа нь харамсалтай. Тиймээс өөрсдийгөө улс төр судлаачид гэж үздэг эрдэмтдийг цуглуулан, эрдэм шинжилгээний чуулга уулзалт зохиож, онолын түвшинд санал солилцуулан, үзэл бодлоо шинжлэх ухааны үүднээс цэгцэлж дэлхий дахины улс төр судлал, улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн явцад нэгдэн орох ёстой болоод байна.

Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРГАМЖ

АЛТАН АРГАМЖ

VOL.3

1/2000

“МОНГОЛ ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ ОНЦЛОГ”

МУИС, ОУХС-ийн
проф. Ж.Баясах

Удиртгал

Монгол Хятад хоёр улс хава дэрлэн 2000 жилийн тэртээ түүхийг туулан өнөрүүлсэн. Тэртээ 2000 жилийн өмнө Монголын Хүннү улс Хятадын Хань улс хоёрын хооронд анхны гэрээ байгуулагдаж Цагаан хэрмээс араар нутаглагч “морьтон ард түмэн” шаньюийн иргэд, Цагаан хэрмийн өмнө зүгээр нутаглагсад “тариа хагалагч ард түмэн” бол Хань улсын иргэд. Үүнээс хойш “морьтон ард түмэн”, “тариа хагалагч ард түмэн” мөр зэрэгцэн эрх эдлэнэ гэсэн нь утгаа хоёр улс их, бага, өндөр, нам гэлгүйгээр тэгш эрх эдлэнэ гэсэн гэрээ юм. XIII зуунд Монгол туургатан хүчирхэгжиж ирэхийн хамтаар феодалын бутралыг эцэслэж Монгол үндэстэн бий болж өөрийн төр улсаа эзэнт гүрний хэлбэрээр дахин мандуулахад аль Сүй Тан улсаас хойш Өмнөд Умардаараа задарсан Хятад орны эхлээд Умард зүгт оршиж байсан Зөрчидийн Алтан улс, Тангадын баруун Ся улс Монголын эзэнт улсад дагаар орж улмаар XIII зууны II хагаст өмнө зүг оршиж байсан Өмнөд Сүн улс Монголд эзлэгдсэнээр Монгол, Хятадын түүхнээ Их Юань улс байгуулагдаж зөвхөн Монгол, Хятад төдийгүй Солонгос болон өмнө зүгийн улсуудыг ноёрхсон билээ. Их Юань улс мөхсөний дараа Монгол улсад Манжид дагаар ортол Умард Юань улс оршин тогтнож байлаа. Энэ улсыг манай түрүү үеийн түүхчид онцгойлон нэрийдэж байгаагүй бөгөөд энэ үеийг феодалын бутралын үе гэдгээр ерөнхийлөн тодорхойлж байлаа.